

СҮХБААТАР АЙМГИЙН ДАРЬГАНГА СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

2022 оны 02 дугаар сарын мэдээлэл

2022.02.24.

Нэг. ТӨРИЙН УДИРДЛАГЫН ЧИГЛЭЛЭЭР.

1. Сумын ИТХ-ын ажлын алба 2021 оны үйл ажиллагаагаар аймагт 5дугаар байрт шалгарсан.
2. Аймгийн Удирдах ажилтны зөвлөгөөнд сумын ИТХ-ын дарга, Засаг дарга, Тамгын газрын дарга, Хууль эрх зүйн мэргэжилтэн нар оролцож, туршлага судлан, 2021 оны тайланг тавилаа.
3. 2022.02.24 ний өдөр сумын “Удирдах ажилтны зөвлөгөөн, сургалтын” арга хэмжээг сумын Соёлын төвд зохион байгуулж, сургалтын удирдамжийн дагуу Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын хүрээнд болон Үр дүнд суурилсан ХШҮ-гээний чадавхыг сайжруулах, цаашид анхаарах асуудал сэдвээр presentation ашиглан сургалт зохион байгууллаа. Мөн “Тэр бум мод үндэсний хөдөлгөөн”-ий хүрээнд тарих модны хуваарийг танилцуулж, гэрээ байгуулах, “Нийгмийн даатгалын тогтолцооны шинэтгэл”, Хөдөлмөр халамжийн чиглэлээр хэрэгжих 7 төслийн талаар танилцуулж, харилцан ярилцлаа.
4. Дээрх зөвлөгөөний дараа багийн Засаг дарга, Албан газрын дарга эрхлэгч нартай сумын Засаг дарга хамтран ажиллах гэрээг үзэглэв.
5. Цар тахалтай холбогдуулан сар шинийн баярыг гэр бүлийн хүрээнд тэмдэглэхийг уриалж уриалга гарган ажилласан.
6. Нийтийн албанд томилогдон ажиллаж байгаа 16 албан хаагчаас ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд нь цахимаар гаргууллаа.
7. Ахмадын хорооны дэргэд “Ахмадуудын өдрийн үйлчилгээ”-г ажиллуулж 20 ахмад амарч сувилуулж байна.
8. Багануурын Ахмадын амралтад 50 ахмад амруулахаар төлөвлөөд ажиллаж байна.

Хоёр. ХӨДӨӨ АЖ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР

1/. 2022.03.02 ны өдөр “МАЛЧДЫН ЗӨВЛӨГӨӨН” зохион байгуулахаар төлөвлөгөө, удирдамжаа батлуулан ажиллаж байна.

2/. 2022.03.07 нд “ТӨЛЧИН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЧУУЛГА” уулзалт зохион байгуулахаар төлөвлөөд ажиллаж байна.

Гурав. СОЁЛ, БОЛОВСРОЛЫН ЧИГЛЭЛЭЭР

1/. Сургууль, Цэцэрлэгийн удирдлагууд 2022 оны 02 дугаар сарын 17 Сүхбаатар аймгийн боловсролын салбарын удирдах ажилтны зөвлөгөөнд оролцож цаашид анхаарч ажиллах асуудал болон хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр, ЭЕШ, “Сүхбаатар нэг мөрөөдөл-ТББ”-аас шилдэг багш, удирдах ажилтан, менежер шалгаруулах үйл ажиллагаа болон сургууль, Цэцэрлэгийнхээ сайн үйл ажиллагааны талаар танилцуулсан

2/. Хүүхдүүдийн ялгаатай байдлыг илрүүлэн хүүхэд бүрт тохирсон дасгал даалгаврыг өгөх, гэрийн даалгаврыг тогтмол шалгаж, ахицыг нь тооцох, эцэг эхтэй холбоотой ажиллах зорилгоор Дунд ангийн багш нарын дунд “Сургуульд суурилсан үнэлгээний үр дүнгийн хэлэлцүүлгийг амжилттай зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт нийт 19 багшаас 12 багш оролцсон.

Уг хэлэлцүүлгээр ССҮ-ний хичээл тус бүрийн, анги тус бүрийн, багш тус бүрийн хичээлийн дундаж хувийг танилцуулан, цаашид 2-р улиралд хоцрогдлыг тодорхой хувиар бууруулахад, хүүхэд бүр дээр ахиц гаргахын тулд хэрхэн хамтарч ажиллах талаар харилцан ярилцаж санал бодлоо солилцсон.

3/. НҮБ-ийн Хүүхдийн сангийн санхүүжилтээр Монголын улаан загалмайн нийгэмлэгээс аймаг, орон нутгийн ерөнхий боловсролын сургууль цэцэрлэг, сургуулийн дотуур байрны тусгаарлах өрөөнүүдийн халдвар хамгааллыг сайжруулах зорилгоор 512,000 төгрөгний өртөгтэй ариун цэврийн 2 багц илгээсэн. Багцаа хүлээн авч, сургуулийн эмч болон дотуур байрын багшид хүлээлгэн өглөө.

4/. Танхимын хичээл эхлэхтэй холбогдуулан 2022.02.13-нд “АРИУН ГЭГЭЭ ГОО” ХХК-аар шавьжгүйтгэлийг сургууль, дотуур байр, спорт заал зэрэг 2000 мкв талбайд хийлгэсэн. Мөн 2022.02.20 ны өдөр тус компаниар халдваргүйжүүлэлтийг хийлгэсэн. 2 сарын 28 нд шавьжгүйтгэлийг давтан хийлгэхээр товлосон.

5/. 2022 оны 2 сарын байдлаар 4 дүгээр тунд 54-н албан хаагчдаас нийт 27 багш, ажилчид 4 дэх тунгийн вакцинд 50%-тай хамрагдсан үүнээс хүндэтгэх шалтгаантай-4, хугацаа нь болоогүй- 13 багш, ажилчид хамрагдсан. 3 дугаар тунгийн вакцинд 2004 оны 18 настай 17 суралцагч 50%-тай 1 дүгээр тунд 2010 оны 12 настай 33 суралцагч 70%-тай хамрагдсан.

Дөрөв. Эрүүл мэндийн чиглэлээр

1/. 2022 оныг “ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ ЖИЛ” болгон зарлаж, сумын Засаг даргаар ахлуулсан Багийн Засаг дарга, Нийгмийн даатгалын байцаагч, Татварын байцаагч, Эмч нарын бүрэлдэхүүнтэй баг хөдөөгийн малчин өрхүүдэд хүрч очин, сургалт мэдээлэл хийж, цаг үеийн нөхцөл байдалтай нь танилцан, ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх

төсөл хөтөлбөрийн саналыг авах , бусад үйл ажиллагааг зохион байгуулан ажиллаж байна.

2/. “ИЛҮҮДЭЛ ЖИНГҮЙ-ЭРТЭЧ МОНГОЛ” аяны хүрээнд “ХӨДӨЛГӨӨН ЭРҮҮЛ МЭНД” уриалгыг гаргаж сумын ЗДТГ-аас эхлүүлэн ажлын байрны дасгалыг өдөр бүр 10 цагаас зохион байгуулж эхэллээ.

3/. Мөн дээрх аяны хүрээнд “Эрэгтэйчүүдийн эрүүл мэнд” хөтөлбөр төлөвлөгөөг боловсруулан төлөвлөгөөний “2022.02.26 наас 27 ны өдрүүдэд дотор, ЭХО ны нарийн мэргэжлийн эмч нарын баг суманд ажиллах үзэр Төсвийн байгууллагуудын эрчүүдийг төлбөрийг нь байгууллага нь хариуцан эмчийн үзлэгт оруулахаар шийдвэрлэв.

МЭДЭЭЛЭЛ БИЧСЭН:МЭРГЭЖИЛТЭН Д. МӨНХЗУЛ

ТАНИЛЦСАН: ЗАСАГ ДАРГА Д. БОЛДБААТАР